



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/401

Булган сум

“Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,
амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөрийг орон нутагт
хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.3 дахь хэсэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/3923 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга
Боловсролын газрын дарга
Цагдаагийн газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр)
Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга (зөвшилцсөнөөр)
Булган аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүлэгч
Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын, Нийгмийн халамжийн хэлтсийн дарга

2. “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөрийг сум, орон нутагт хэрэгжүүлэх ажлын хэсгийг мэргэжил арга зүйгээр хангаж, ажлыг үр дүнтэй зохион байгуулан, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2026 оны А/220 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР